



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/468.

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Ахмадын хорооны
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 162,810.00 (нэг зуун жаран хоёр мянга найман зуун арав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн Ахмадын хороо (Б.Отгонпүрэв)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 1 нэр төрлийн 54,270.00 (тавин дөрвөн мянга хоёр зуун дал) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 1 нэр төрлийн 108,540.00 (нэг зуун найман мянга таван зуун дөх) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Налайх дүүргийн Ахмадын хороо (Б.Отгонпүрэв)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150502180

